

хийн эдийн засгийн хөгжилд ч ашигтай<sup>9</sup> гэж хятадын удирдлага үзэж байна.

Нөгөө талаар, хятадын улс ардын аж ахуйн шинэчлэлтийн нэг гол зорилго нь үндэсний батлан хамгаалалтыг шинэчлэх явдал бөгөөд иймээс ч Бээжингийнхэн гадаадаас цэргийн технологи авахыг ихээхэн сонирхож байна.

АНУ-ын зэвсэг хянах, зэвсэглэлийг хориглох агентлагийн мэдээлснээр, 1981 онд БНХАУ нь зэвсэг экспортлох талаар дэлхийд 10-р байранд орж байсан бол жилийн дараа 5-р байрыг эзлэх болжээ.<sup>10</sup>

Энэ мэдэгдлийг хийхдээ, АНУ юуны өмнө, зэвсэг, цэргийн техник технологи экспортлохдоо хууль зүйн хязгаар тогтоож, Бээжин-Вашингтоны харилцаанд Зөвлөлт хэрхэн хандаж буй, мөн Хятадын ардын чөлөөлөх армийн хүчин чадал, Ази, Номхон далайн бүс нутаг дахь Вашингтоны холбоотнуудын ашиг сонирхол зэрэг хүчин зүйлийг харгалзан үзсэн байна.

Хятадын удирдагчид, юуны өмнө, богино хугацаанд гадаад ертөнцтэй эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн харилцааг эрчимтэйгээр хөгжүүлэх замаар тус орныг хүчирхэг гүрэн болгон хувиргахыг эрмэлзэж байна. Үүний тулд тэд улс орныхоо шинэчлэлтийн программыг хэрэгжүүлэх үүднээс АНУ-ын хүсэл сонирхлын дагуу зохих зарим нөхцөлийг хангаж өгч, хариуд нь хэрэгцээт туслалцаа авахыг хичээж байна.

БНХАУ, АНУ хоёрын харилцаа хэвийн болсонтой адил, хоёр орны эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн салбар дахь хэлхээ холбооны хөгжил нь олон улсын байдлыг ерөнхийд нь сайжруулахад чиглэж байгаа бол энэ нь Ази, Номхон далайн бүс нутаг төдийгүй, хоёр орны болон даян дэлхийн ард түмний эрх ашигт нийцэх бөгөөд энх тайвныг сахин хамгаалахад ашигтай зүйл болно,

### **ХЯТАД-ЯПОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ХАРИЛЦААНЫ ӨНӨӨГИЙН ЗАРИМ АСУУДАЛ**

**Б. Сэржав**

1980-аад оны эхээс эдийн засгийн нээлттэй бодлого баримталж ирснээс хойш Хятад улс эдийн засгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, гадаадын тэргүүний техник технологи олж авахад зориулж, гадаад бүх эх сурвалжаас улс ардын аж ахуйд 55 млрд. долларын хөрөнгийг оруулжээ. Энэ нь ч зохих үр ашгаа өгсөн юм.

1. «Исьюз энд стадиз». Тайбэй (Тайвань), 1988, № 2, хх. 92-94
2. «Жэньминь жибао» 1988, III. 11
3. «Синьхуа юебао», 1988. № 5
4. «Бэйжин ревью» 1987, IX, 7, х. 8—9
5. Мөн тэнд, 1983, П. 23, х, 29
6. «Бэйжин ревью» 1987. II. 16, х, 31
7. «Жэньминь жибар», 1988. XI, 28
8. «Жэньминь жибао», 1988. 1, 26.
9. Мөн тэнд. 1985. VII. 26
10. «Исьюз энд стадиз». Тайбэй (Тайвань). 1986. № 3, х. 16

1987 онд хуралдсан ХКН-ын XIII их хурлын баримт бичигт улс орны эдийн засгийн хөгжлийг хурдасгах, үр ашгийг дээшлүүлэхэд «эдийн засгийн гадаад харилцааг цаашид өргөтгөн гүнзгийрүүлж, гадаад орнуудтай хийх худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааг хөгжүүлэх явдал чухал үүрэг гүйцэтгэх ёстой»<sup>2</sup> гэж онцлон тэмдэглэжээ.

Хятад улс эдийн засгийн гадаад харилцаандаа Японд илүү найдлага тавьж, улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн салбарт өргөн цар хүрээтэй хамтран ажиллаж байна. Өнөөгийн байдлаар Хятадын эдийн засгийн гадаад харилцаанд Япон улс гол түнш нь болов, БНХАУ-ын Төрийн зөвлөлийн ерөнхий сайд Ли Пэн 1989 оны дөрөвдүгээр сард Японд айлчлах үедээ хоёр орны эдийн засаг, шинжлэх ухаан-техник, соёлын харилцаа сүүлийн жилүүдэд улам өргөжиж ирснийг онцлон тэмдэглэсэн.

Хятад-Японы эдийн засгийн хамтын ажиллагаа өнөөдөр худалдаа хөрөнгө оруулалт, техник технологи нийлүүлэх, мөнгөн зээллэг зэрэг хэд хэдэн чиглэлээр хөгжиж байна.

Хятад, Японы хооронд 1972 онд дипломат харилцаа тогтохоос өмнө зөвхөн худалдааны харилцаатай байлаа. Дипломат харилцаа тогтсоноос хойш энэ харилцаа улам өргөжиж ирсэн бөгөөд 1987 онд тус хоёр орны худалдааны нийт хэмжээ 16 млрд. 500 сая доллар хүрч 1977 оныхоос даруй 3 дахин нэмэгдсэн ажээ.<sup>3</sup>

Хятад-японы худалдааны ерөнхий хандлагаас үзэхэд 80-аад оноос Хятад улсад аж ахуйн шинэчлэл, эдийн засгийн нээлттэй бодлогыг хэрэгжүүлж эхэлсэнтэй уялдан, гадаад худалдаанд экспортоос импортын эзлэх хувь давамгайлах болов. Ялангуяа Японоос оруулж буй импортын барааны хэмжээ гэнэт өсч, Япон улсын импортоос давсан экспортын хэмжээ 1984 онд 1 млрд. 200 сая доллар байсан бол 1985 онд 6 млрд доллар, 1986 онд 4 млрд. 200 сая доллар, 1987 онд 850 сая доллар болсон байна.<sup>4</sup>

Хятадаас Японтой хийсэн экспортын худалдаа 1987 онд урьд оныхоос 29,0 хувь нэмэгдэж 39 млрд 921 сая доллар, импорт 2,2 хувь өсч 43 млрд 856 сая долларт хүрсэн байна. Японтой хийж буй худалдааны алдагдал 11 млрд 970 сая доллар байсан бол 1987 онд 3 млрд 935 сая доллар<sup>5</sup> болж хорогджээ. Хятадтай худалдааны харилцаатай улс, бүс нутгийн дотор олон жилийн турш Япон улс тэргүүн байранд орж байсан бол 1987 онд Гонконг-Макаогийн дараа хоёрдугаарт орох болжээ.

Хятад улс Японоос үйлдвэрийн зориулалттай машин техник, тоног төхөөрөмж, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, автомашин, ган, төмөрлөгийн бүтээгдэхүүн, химийн бордоо, ургамлын тос зэргийг худалдан авч, Японд нефть, нүүрс, хүнсний ногоо, эрдэнэ шиш, мах, газар тариалан, ой, далайн бүтээгдэхүүн, хөвөн, сүлжмэл зэрэг бүтээгдэхүүн нийлүүлдэг байна.

1988 оны эхний хагаст Японд Хятадаас авсан импортын бараа 4 млрд 600 сая доллар (урьд оны мөн үеийнхээс 38,6 хувиар өссөн), Хятадад гаргасан экспортын хэмжээ: 4 млрд 100 сая доллар (урьд оны мөн үеийнхээс 3,4 хувь өссөн) -т хүрч импортын хэмжээ экспор тоос давжээ.<sup>6</sup> Сүүлийн үед нэг талаас Японы иений ханш эрс дээшилж, гадаад худалдаанд экспортын хэмжээ буурахад хүрсэн, нөгөө талаас Хятад улсад Японоос оруулах импортын зарим бараанд хязгаарлалт тогтоосон зэргээс шалтгаалан Японоос Хятадтай хийж буй худалдаанд экспортын хэмжээ буурч эхэлсэн байна. Энэ нь нэгд, иений ханш дээшилснээс хятадын нэхмэл, сүлжмэл зэрэг хөнгөн үйлдвэрийн бүтээг-

дэхүүнийг их хэмжээгээр оруулах болсон хоёрт, хятадын экспортын гол бүтээгдэхүүний нэг түүхий нефтийн үнэ өсч хэвийн байдалд хүрсэн, гуравт, хятадын бүтээгдэхүүнийг Японд худалдан авах хэмжээг өргөжүүлэх талаар хоёр талаас хүчин чармайлт гаргаж байгаагийн үр дүнд Японы импортын хэмжээ өсөх хандлагатай болсон зэрэг шалтгаан нөхцөлүүдээр тайлбарлагдана.

Япон улстай хийж байгаа худалдаанд тэнцвэртэй байдал тогтоон бататгах, мөн дотоод хэрэгцээгээ зохицуулах үүднээс Хятад улс саяхнаас импортын хэмжээг багасгах, нефтийн үнийг хуучин хэмжээнд хүргэх талаар хүчин чармайлт гаргаж ирлээ. Тухайлбал, импортоор авч буй барааны дотор 1987 онд урьд оныхоос машин, тоног төхөөрөмжийг 19,1 хувь, барилгын машин техникийг 26,3 хувь, автомашин, тээврийн бусад хэрэгслийг 44,9 хувиар тус тус багасгасан байна.

1985 онд Японоос Хятадад 117436 суудлын машин, 106758 ачааны машин экспортлож байсан бол 1986 онд суудлын машин 5937, ачааны машин 46111, 1987 онд суудлынх 4501, ачааных 12166 болж хорогджээ<sup>7</sup>. Мөн өмнөх жилүүдэд их хэмжээгээр худалдан авч байсан ган, хуванцар, нэхмэл эдлэл, нийлэг утасны хэмжээг хорогдуулсан байна.

Харин Японоос худалдан авах шуудан холбооны болон дүрс бичлэгийн хэрэгсэл, хагас дамжуулагчийн хэмжээ нэмэгдэж, 1986 онтой харьцуулахад 1987 онд зурагт радио 13,8 хувь, хөргөгч 41,7 хувь, угаалгын машин 16,2 хувь тус тус өсчээ<sup>8</sup>.

Хятадын хувьд Японд гаргах хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, нүүрс, нэхмэлээс бусад бараагаа нэмэгдүүлсэн байна. Тухайлбал, 1987 онд 12 сая 190 мянган тонн түүхий нефть худалдсан нь өмнөх жилийнхтэй харьцуулахад 30,7 хувиар нэмэгдсэн байна. 1986 онд баррель тутамд оногдох түүхий нефтийн үнэ 13 доллар байсан бол 1987 онд 17 доллар болж өсчээ<sup>9</sup>. Мөн Хятадын далайн гаралтай бүтээгдэхүүн, жимс, ногоо, нэхмэл барааны экспорт өмнөх жилийнхээс ихээхэн өссөн байна.

1987 оны зургадугаар сард Бээжинд болсон Хятад, Японы сайд нарын ээлжит тавдугаар хуралдаанаар хоёр орны худалдааг хөгжүүлэх асуудлыг хэлэлцэж, Хятадад үйлдвэрлэсэн торго, гар хийцийн дээд ангиллын хивс зэрэг 38 нэр төрлийн бараанд японы зах зээлийг нээх тухай ярилцсан байна. Япон улс Хятадаас торго худалдан авахад хязгаарлалт тогтоосны уршгаар сүүлийн 10 жилд Хятад улсын торгоны экспорт жил дараалан буурч байгааг зогсоох, сүрэл, сүрлэн бүтээгдэхүүн, хүнсний ногоо, жимс, мах, махан бүтээгдэхүүнд тавьж буй хориг цээрээ зогсоохыг Хятадын тал хүссэн юм. Японы талаас Хятадын талд бүтээгдэхүүнийхээ олон улсын зах зээл дээр өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, ялангуяа бүтээгдэхүүний үнэ, чанарын асуудалд анхаарах, бараа таваар нийлүүлэх хугацааг чанд мөрдөх, худалдах борлуулах үйлчилгээгээ сайжруулах шаардлагыг тавьж иржээ.

Хоёр орны тодорхой хүчин чармайлтын үр дүнд Хятад-Японы худалдаанд тэнцвэртэй байдал бий болох хандлага байгаа хэдий боловч энэхүү тэнцвэртэй байдлыг тогтоохдоо худалдааг хорогдуулах замаар зохицуулж буй нь тодорхой харагдаж байна. Иений ханш өссөнөөр Хятад улс Японоос авах импортоо хасахад хүрч, юаний ханш буурснаар Хятадын барааг Японд оруулах хэмжээ нэмэгдсэн явдал худалдааны тэнцвэр бий болоход ямар нэгэн хэмжээгээр нөлөө үзүүлж байгаа нь ойлгомжтой юм. Хятадын шинэчлэлийн үйл хэрэгт японы бүтээгдэхүүний импорт хойшид ч зохих ач холбогдолтой байх нь ойлгомжтой. Гэтэл Хятад улсад үйлдвэрлэж буй ихэнх бүтээгдэхүүн одоогоор Японы зах зээл дээр өрсөлдөж чадах хэмжээнд хүрээгүй

байна. Чухамдаа Японы зах зээл дээр өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүнийхээ тоог олшруулах явдал хятад-японы худалдааны тэнцвэргүй байдлыг арилгахад тодорхой нөлөө үзүүлж чадах юм.

Хятад улс эдийн засгийн шинэчлэлийн бодлого хэрэгжүүлэхдээ гадаадын хөгжингүй орнуудтай хамтран ажиллаж, тэдгээр оронтой хөрөнгө хорших, дан гадаадын хөрөнгөөр байгуулах, гадаадын пүүстэй хамтран тэнгэсийн нефтийн нөөцийг эрж олборлох зэрэг хамтын ажиллагааны олон хэлбэрийг өргөн ашиглаж үйлдвэр аж ахуйн газруудыг олноор барьж байна. 1988 оны нэгдүгээр сард Хятадын гадаад эдийн засаг худалдааны яамнаас гаргасан тоо бүртгэлээс үзэхэд 1979 оноос 1987 оны сүүлч хүртэл Хятад улсад дээрх чиглэлийн үйлдвэр аж ахуйн 10052 газар байгуулж, түүнд 25 млрд долларын хөрөнгө оруулжээ. Эдгээр үйлдвэр аж ахуйн газарт Япон улсаас оруулсан хөрөнгө 2 млрд. 100 сая доллар буюу нийт хөрөнгө оруулалтын 8,4 хувийг<sup>10</sup> эзэлнэ. Энэ үзүүлэлтээрээ Япон улс Хятад улсад хөрөнгө оруулж буй гадаадын улсуудын дотор Гонконг, Америкийн дараа гуравдугаарт орж байна. Ингэж Японтой хамтран төрөл бүрийн үйлдвэр аж ахуйн газар байгуулж, тэдгээрт зориулан хөрөнгө оруулах явдал хятад-Японы эдийн засгийн хамтын ажиллагааны нэг томоохон салбар болоод байна. Японы хөрөнгө оруулалтаар Хятадад 1979— 1983 онд 10, 1984 онд 47, 1985 онд 95 үйлдвэр аж ахуйн газар шинээр байгуулж, жилээс жилд олширч ирсэн боловч 1986 оноос хойш Япон улс Зүүн Өмнөд Азийн орнуудад энэ чиглэлээр хөрөнгө оруулах явдлыг чухалчлан үзэх болжээ. Японоос сүүлийн үед Хятадад байгуулах томоохон үйлдвэрийн газарт хөрөнгө оруулахаар тохиролцоод байгаагийн зарим жишээг дурдвал, цахим хэрэгслийн үйлдвэрийн Мицүи пүүсээс Гонконгийн ижил төрлийн үйлдвэртэй хамтран нийт хөрөнгийн (9 сая 500 мянган доллар) 25 хувийг, Шанхайн цахим хэрэгслийн үйлдвэрийн компани, Хятадын техникийн экспортын пүүс хамтран үлдсэн 75 хувийг тус тус гаргаж, «цахилгаан шатны Шанхай-Мицүи компани» -ийг байгуулахаар тохиролцоод байна. Энэ хамтарсан үйлдвэрийн хугацаа 25 жил ажээ. Түүнчлэн Японы Мацушита Дэнки пүүсээс Бээжин хоттой хамтран «Бээжин— Мацушита өнгөт телевизийн дэлгэц үйлдвэрлэх пүүс»-ийг байгуулж, уг пүүсийг байгуулахад шаардагдах 20 млрд нений тал хувийг нийлүүлэхээр тохиролцсон бөгөөд энэ үйлдвэрийн хамтран ажиллах хугацаа нь 20 жил юм. Уг пүүст 1987 оноос эхлэн 21 инчийн (2,5 см) телевизийн дэлгэц 800 мянган ширхэгийг үйлдвэрлэх ажээ<sup>11</sup>.

1988 оны эхний хагас жилийн байдлаар Японоос Хятадын 50 гаруй үйлдвэр аж ахуйн газарт нийт 2 млрд долларын хөрөнгийг оруулаад байгаа хэдий ч Хятадын тал энэ тоог чамлалттай гэж үзэж байна. Япон улс Хятадтай хөрш зэргэлдээ оршдог хэдэн мянган жилийн харилцааны түүхтэй атал, чухам ямар учраас дөнгөж 1979 онд дипломат харилцаа тогтоосон, газар нутгийн байрлалын хувьд ч алс хол орших, худалдааны харилцаагаар ч төдий л өргөн бус Америк улстай адилаар 500-хан барилга байгууламжид хөрөнгө оруулж байна вэ? гэсэн асуулт ч хятадын талаас гарч буй ажээ.

Япон улс Хятадад жилд дунджаар 1 млрд 900 сая долларын хөрөнгө оруулж байхад Америк улс далайн ёроолд нефтийн түүхий эд хайх, нүүрсний орд газар, ашигт малтмал нээж ашиглах чиглэлийн том хэмжээний үйлдвэрийн барилга байгууламжид зориулж жилд дунджаар 3 млрд 40 сая долларын хөрөнгө оруулж байна. Япон, Америк хоёрын Хятадад оруулсан хөрөнгө оруулалтыг харьцуулан үзэхэд хэдийгээр нэг байгууламжид оруулах хөрөнгийн хэмжээ тэнцүү байгаа боловч Японы хувьд шууд үйлдвэрийн салбарт биш харин зочид буудал зэрэг үйлчилгээний салбарт ихэвчлэн хөрөнгө оруулж байхад Аме-

рик улс голдуу шууд үйлдвэрлэлийн салбарт хөрөнгө оруулж байгаа ажээ. Хятадтай хийж байгаа худалдааны хэмжээгээр Америкаас хоёр дахин их байгаа Япон улс мөн төдий хэмжээний хөрөнгийг Хятадад оруулах хэрэгтэй гэсэн үзэл баримтлал ч Хятадын талд байсаар байна.

Японоос Хятадад хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд 1988 оны наймдугаар сард Японы ерөнхий сайд Такэшита БНХАУ-д айлчлах үеэр гарын үсэг зурсан «Хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих Хятад-Японы гэрээ» чухал ач холбогдолтой болсон юм. нийт 15 зүйл бүхий 10 жилийн турш хүчинтэй байх уг гэрээнд Хятад улсад хөрөнгө оруулж буй Японы үйлдвэрүүдийг Хятадын үйлдвэр аж ахуйн газартай адил хэмжээнд авч үзэх тухай, улсад нийгэмчлэх арга хэмжээ авагдсан тохиолдолд хохирлыг нөхөн төлөх тухай, хоёр улсын хоорондын төлбөр илгээмж зэрэг асуудлыг тодорхой заасан байна. Энэ гэрээ нь хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагаа, техникийн солилцоог хөгжүүлэхэд таатай нөхцөл бүрдүүлж өгөх, хөрөнгө оруулалтаар авсан эд хөрөнгийн хамгаалалт, ашиглалтыг сайжруулах зорилготой ажээ. Дашрамд тэмдэглэхэд үүнээс өмнө Хятад улс ийм гэрээг 21 оронтой байгуулсан аж.<sup>12</sup>

Дээрх гэрээнээс өмнө 1986 оны аравдугаар сард хятад- японы хөрөнгө оруулалтыг урамшуулах дүрмийг боловсруулж мөрдсөн зэрэг хөрөнгө оруулалт, хамтарсан үйлдвэрийн асуудлаар чармайлт гаргасаар ирсэн юм. Гэвч үйлдвэр аж ахуйн газруудыг хамтран байгуулсан хоёр орны ашиг сонирхол зөрчилдөх явдал ч байсаар байна. Тухайлбал, японы аж үйлдвэрийнхэн хамтарсан үйлдвэрийн бүтээгдэхүүнийг хятадын дотоод зах зээл дээр их хэмжээгээр борлуулахыг сонирхож байхад хятадын талаас уг үйлдвэрийн бүтээгдэхүүнийг экспортод гаргах шаардлага тавьсаар ирсэн юм.

Хятадын худалдаа аж үйлдвэрийнхэн олон улсын худалдаанд ёс горимыг баримталдаггүй, аж үйлдвэрт хөрөнгө зардал гаргах чадвар сул, хөрөнгө зардлыг зохих ёсоор үнэлдэггүй, нэгэнт тохиролцсон гэрээнээс буцдаг, бүтээгдэхүүнийг дотоод, гадаадын зах зээл дээр борлуулах мэдээлэл хангалтгүй, мөн улс төр, эдийн засгийн байгууллын ялгаанаас болж капиталист аж үйлдвэрийн талаархи тэдний ойлголт нимгэн гэх мэт шалтгаанаас японы аж үйлдвэрийнхэн Хятад улсад хөрөнгө оруулаад хашин хойрго хандах явдал байсаар байна.

Хятад, япон хоёр улс техник, технологийн салбарт өргөн хамтын ажиллагаа явуулж байна. Энэ хамтын ажиллагаа нь үйлдвэр аж ахуйн газрын иж бүрэн тоног төхөөрөмж нэвтрүүлэхээс эхлээд машин техник, лиценцийн худалдаа, шинэ техник технологи нийлүүлэх, судлаачид, инженер техникийн ажилтан, мэргэжилтнийг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, техник, технологийн хамтын ажиллагааны тусгай төсөл зохион хэрэгжүүлэх зэрэг олон хэлбэртэй, 1981-1986 онд Японы талаас 9 млрд. 400 сая долларын үнэ бүхий 2141 нэр төрлийн техник технологи Хятадад нийлүүлжээ. Зөвхөн 1986 онд Хятад улсад гаднаас оруулсан техник технологийн 24 хувийг Япон улс дангаар оруулсан байна.<sup>13</sup>

Мөн Японы засгийн газрын шугамаар олон улсын хамтын ажиллагааны агентлаг (JICA) -аас хариуцан 1978 оноос эхлэн жил тутам Хятадын техникийн ажилтнуудыг хүлээн авч мэргэжил дээшлүүлэх ажлыг хийж байгаа бөгөөд 1987 оныг хүртэл энэ шугамаар 1500 гаруй хүн бэлтгэсэн байна. Мөн 1987 оныг хүртэл 900 орчим мэргэжилтнийг давтан сургаж, 2300 гаруй хүн үйлдвэрлэлийн дадлага хийсэн байна.<sup>14</sup>

Хоёр орны хооронд 1981 оноос хэрэгжиж, Бээжинд «Хятад-Японы найрамдлын эмнэлэг» байгуулах ажлаар эхэлсэн техник технологийн

хамтын ажиллагааны тусгай төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд хоёр орон нягт хамтран ажиллаж байна. Тухайлбал, Бээжинд өрх гэр төлөвлөлт, аж үйлдвэрийн удирдлагын эрдэм шинжилгээний төв, мах, махан бүтээгдэхүүний судалгааны нэгдсэн төв, Санцэяний газар тариалангийн туршлагын нэгдсэн төвийн төлөвлөлт, Лиценз, патентын мэдээлэл, лавлагааны сургалтын газар, Бээжингийн шуудан, цахилгаан холбооны сургуулилын төв, Тахир дутуу хүмүүст зориулсан нөхөн сэргээх эмчилгээний төв зэрэг байгууламжийг барих ажил хийгдэж байгаагийн дотор Японы буцалтгүй хөрөнгөөр байгуулж буй газар ч олон байна.

1987 оныг хүртэл Япон улсаас Хятадад 35 млрд 80 сая иений буцалтгүй тусламж үзүүлсний дотор Чанар стандартын судалгааны төв, Бээжингийн нуур цөөрөмд загас үржүүлэх төв, Чанчун хотын ус цэвэрлэх төхөөрөмж, Хятад-японы залуучуудын солилцооны төв<sup>15</sup> зэргийг байгуулсан юм.

Японы техник технологийг Хятадад нэвтрүүлж байгаа өөр нэг хэлбэр нь аж үйлдвэрийн газрын техник, тоног төхөөрөмжийг иж бүрнээр шинэчлэх ажиллагаа бөгөөд энэ үйл ажиллагаа хоёр орны хооронд 1981 оноос эхлэн хэрэгжиж ирлээ. Аж үйлдвэрийн газрын техник тоног төхөөрөмжийг шинэчлэх үйл ажиллагаа нь Хятад, Япон хоёр улсын засгийн газруудын хоорондын гэрээ хэлэлцээр болон БНХАУ-ын Эдийн засгийн улсын хорооны хүсэлтийг үндэслэн хэрэгжиж байна. Японы талын хувьд энэ үйл ажиллагааг засгийн газар хоорондын болон засгийн газар хоорондын бус гэсэн хоёр шугамаар явуулж байна. Тухайлбал дээр дурдсан нэгдүгээр шугам болох Олон улсын хамтын ажиллагааны агентлагийн шугамаар Хятадын аж үйлдвэрийн газруудын шинэчлэлтэд хамтран ажиллаж 1981 онд 6, 1982 онд 8, 1983 онд 6, 1984—1987 онд жил тутам 8 үйлдвэрийн газарт оношлогоо, техникийн шинэчлэлтийн төслийг хэрэгжүүлсэн нь нийтдээ 52 үйлдвэрийг<sup>16</sup> хамраад байна. Гэвч хятадын талаас энэ ажлыг гүйцэтгэгч байгууллага болох Хятадын эдийн засгийн улсын хорооноос жил бүр 20—30 үйлдвэрийн газрыг шинэчлэхээр төсөл боловсруулж, Японы талд илгээсээр байгаа нь тоног төхөөрөмжийг шинэчлэх шаардлагатай үйлдвэрийн газар Хятад улсад нэлээд олон байгааг гэрчлэх баримт мөн. Ингэж үйлдвэрийг шинэчлэхэд Хятадын талын тухайн үйлдвэрийг хариуцсан гол хүмүүс Японд очиж хамтран ажиллах үйлдвэрээ олж тохиролцсоны үндсэн дээр Японы үйлдвэрээс мэргэжилтэн ирүүлж, шинэчлэх үйлдвэрт оношлогоо тавьж, Хятадын талтай хамтран төлөвлөгөө боловсруулсаны дараа шаардлагатай тоног төхөөрөмж, техникийг нийлүүлдэг ажээ. 1981-1988 онд Хятадын 180 үйлдвэрт шинэчлэлт хийх оношлогоо тавиад байна. Сүүлийн үед энэ үйл ажиллагаанд тохиолдож байгаа зарим асуудлаас дурдахад юуны өмнө Японд иений ханш гэнэт өссөний нөлөөгөөр японы аж үйлдвэрүүд үнийн талаар өрсөлдөх чадвар суларч, машин тоног төхөөрөмжийг экспортод гаргах явдал ихээхэн төвөгтэй болж ирсэн байна. Ийм чиглэлээр хамтран ажиллах үйлдвэрийн газар цөөрч болзошгүй гэж Хятадын тал үзэж байна.

Үйлдвэрийн газрын тусгай төслийн дагуу барьж байгуулах, шинэчлэн тоноглох үйл ажиллагаа нь хятад- японы хамтын ажиллагааны нэлээд эрчимтэй явагдаж буй салбарын нэг юм. Гэвч энэ ажиллагааны цаашдын хөгжлийг найдвартай хангаж байхын тулд шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлууд бас байна. Тухайлбал, Японы худалдаа, аж үйлдвэрийнхний үзэж байгаагаар техник технологийн экспортын хэлэлцээ хийхэд хэтэрхий их цаг зарцуулдаг, машин техникийг сонгон авах хэлэлцээ хийх шийдвэрлэх эрхийг барьж байгаа

эрх мэдлийн байгууллага тодорхойгүй, ялангуяа Хятад улсад төлөөлөгчид, ажлын хүмүүсийг хэд хэдэн удаа явуулах зэрэгт цаг, зардлыг ихээхэн үрж байгаа, үйлдвэрийг шинээр тоноглох ажил дөнгөж эхлэлийн шатандаа явж байхад бүтээгдэхүүний чанарын эцсийн баталгааг шаарддаг гэх мэтээр сэтгэл дундуур тал байсаар байна.

Техник технологийн хамтын ажиллагааны үр дүнд эцсийн эцэст Хятадын үйлдвэрийн газрууд удаан жилийн турш найдвартай ажиллах боломжийг олж авах явдал хамгийн чухал гэдгийг бодолцохгүйгээр аль болохоор хямд төсөр арга замыг эрж хайх сонирхолтой гэсэн шүүмжлэл японы үйлдвэрийнхэнд байсаар байна. Хятад улс валютын нөөц хүрэлцээгүй байгаа нь үйлдвэрийн газруудад ч нөлөөлсөөр байгаа бөгөөд ийм шалтгааны улмаас японы үйлдвэрийн газрууд үлэмж хэмжээний материалыг зарцуулж, хүч чармайлт гаргаж ид ажлын үедээ явахад Хятадын талаас гэнэт холбоо тасалдах, эхний төлөвлөгөөгөө өөрчлөх зэрэг зохисгүй үзэгдэл гаргасаар байдаг аж.

Мөн ажил хэргийн хэлэлцээний үед Хятад улс олон улсын тогтсон журмаас хатуу байр суурь баримталдаг, техник технологийн үнийг хямдаар тооцоолохыг оролддог, баталгаа хариуцлага их тулгадаг, техник технологийг өөрийн болгож эзэмших чадвар дорой гэж япончууд үзэж байна. Түүгээр зогсохгүй Хятад улс тэргүүний техник, технологийг дотооддоо нэвтрүүлэх явдал ихээхэн удаашралтай, Японд мэргэжил эзэмшсэн ажилтнууд техник, технологийг ганцаараа эзэмших сонирхолтой, үүнээс болоод нэг пүүсийн технологи, нөгөө үйлдвэр компанид нэвтрэхгүй, далайн эрэг хавийн районы техник технологи нутгийн гүн рүү нэвтрэхэд бэрхшээлтэй, армид нэвтэрсэн технологи иргэний салбарт нэвтрэхгүй байгаа зэргийг Японы тал зүй ёсоор шүүмжилж байна.

Хятад-Японы эдийн засгийн хамтын ажиллагааны зонхилох нэг хэсэг нь Японоос Хятадад үзүүлж байгаа мөнгөн зээллэг, бараа таваарын зээллэг юм. Японы ерөнхий сайд агсан М. Охира 1979 оны арван хоёрдугаар сард БНХАУ-д айлчлах үедээ анх удаа Хятадын шинэчлэлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд зориулж 1979-1983 онд 330 млрд иен (1.3 млрд доллар)-ий зээллэгийг олгохоор тохиролцсон юм<sup>17</sup> Энэ зээллэг нь Чунжоу-Шизюсуо, Бээжин-Цинхуандаогийн төмөр зам, Шизюсуо, Цинхуандаогийн боомт зэрэг Хятадын экспортын гол түүхий эдийг далайн боомт хотуудад тээвэрлэхэд чухал ач холбогдолтой төмөр зам, боомт хотуудыг барьж байгуулахад зориулагджээ. Мөнгөн зээлийн тусламжаар байгуулж, 1985, 1986 онуудад ашиглалтад оруулсан зам харилцааны дээрх 6 барилга байгууламж Хятадын эдийн засгийн хөгжилд зохих хувь нэмрээ оруулж ашигтай ажиллаж байна. Мөн энэ үед Японоос оруулсан экспортын нөөц фондоор Шанхайн Баошаны төмөрлөгийн үйлдвэр, Дацинши-ийн тоног төхөөрөмжийн үйлдвэр байгуулж ашиглалтад оруулжээ. Энэхүү анхны зээллэг нь Хятадын улс ардын аж ахуйг хөгжүүлэх VI таван жилийн төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэхэд зохих ёсоор нөлөөлж үр ашгаа өгсөн байна.

Японоос Хятадад олгох хоёр дахь удаагийн зээллэгийг 1984 оны гуравдугаар сард Японы ерөнхий сайд байсан Я. Накасонэ БНХАУ-д айлчлах үедээ 1984-1989 онд 7 жилийн хугацаатай, 3,5 хувийн хүүтэй 470 млрд иен (тухайн үеийн ханшаар 2 млрд 130 сая доллар) -ий зээллэг олгосон юм.<sup>18</sup> Энэ зээллэгийг Хэнянь-Гуанжоу, Жэнжоу-Баожигийн төмөр замын өргөтгөл, Цинхуандао, Ляньюнь, Циндаогийн усан боомтыг өргөтгөн байгуулах Тянжин, Шанхай, Гуанжоу хотуудад цахилгаан дамжуулах шугам, Тяньшэнцяогийн усан цахилгаан станц зэрэг 7 барилга байгууламжийг санхүүжүүлэхэд зориулсан юм.

Хятад улс Японоос хоёр дахь удаагаа зээллэг авсан энэ үе нь японы иений ханш ихээхэн дээшилсэн үе байсан учир дээрх 7 байгууламжийн төсвөөс 100 млрд иений үлдэгдэл гарч, анх төлөвлөсөн дээрээ 9 барилга байгууламжийг нэмж санхүүжүүлжээ.<sup>19</sup>

Японы ерөнхий сайд агсан Н. Такэшита 1988 оны наймдугаар сард БНХАУ-д айлчлах үедээ Хятад улсад Японоос олгох гурав дахь удаагийн мөнгөн зээллэгийн тухай хэлэлцэж, 810 млрд иений зээллэгийг олгохоор тохиролцсон юм.<sup>20</sup> Энэ удаагийн зээллэг нь хэмжээний хувьд хоёр дахь удаагийн зээллэгээс 1,5 дахин их бөгөөд Хятадын 42 барилга байгууламжид ашиглахаар төлөвлөсний дотор Хунань, Гуйжоу, Гуаньси, Шаньси муж болон Бээжин хотод 600 мянган кВт-аас 1 сая 200 мянган кВт-ын хүч чадалтай 8 цахилгаан станц, Юнань, Цзяньси, Гуаньси, Гуйжоу муж, ӨМӨЗО-д жилдээ 240 мянгаас 4 сая тонн фосфорын болон аммиакийн бордоо үйлдвэрлэх хүч чадал бүхий химийн бордооны 6 үйлдвэр, төмөр зам, боомт хот, томоохон гүүр зэрэг зам тээврийн ач холбогдолтой 15 барилга байгууламжийг байгуулахаар тохиролцсон<sup>21</sup> байна. Энэ удаагийн зээллэгийн ихэнхийг Хятад улс орныхоо эдийн засгийн дэд бүтцийг шинэчлэн байгуулахад зориулж байгаагийн зэрэгцээ утсан харилцааны шугам, усан зам гэх мэтийн жижиг хэмжээний барилга байгууламжийг ч хамруулсан байна.

Үүнээс гадна Японы засгийн газар гадаад худалдааны орлогоор хөгжиж байгаа орнуудад туслах фондыг байгуулсан бөгөөд 1987 оны есдүгээр сард ерөнхий сайд агсан Я. Накасонэ Япон Хятадын дипломат харилцааг сэргээсний 15 жилийн ойн үеэр Хятад улсад 100 млрд иений тусламж олгох, Хятадын нэхмэл, сүлжмэл, техник, түүхий эд, газар тариалан, мал аж ахуй, загасны аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт импортоо нэмэгдүүлэх тухай мэдэгдсэн юм.

Хятад-Японы эдийн засгийн харилцаанд хоёр улсын хүлээн зөвшөөрсөн «Хятад-Японы эдийн засгийн хамтын ажиллагааны гурван зарчим»-ыг мөрдлөг болгож ирлээ. Энэ зарчмын ёсоор Япон улсаас **нэгд**, Хятад улсад цэргийн тусламж үзүүлэхгүй; **хоёрт**, эдийн засгийн тусламжийн хувьд Хятад улсыг Азийн бусад улс, ялангуяа АСЕАН-ы орнуудаас илүүд үзэхгүй; **гуравт**, Япон улс Хятадын зах зээлийг дангаар ноёрхохгүй байх ажээ. Гэвч зарим заалт тухайлбал, хоёрдугаар зарчимд заасан Хятадад үзүүлэх эдийн засгийн тусламжийг АСЕАН-ы орнуудтай адил тэгш хандах явдал эсрэгээр эргэж, Хятадад илүү тусламж үзүүлсээр байгаа юм.

Хятад-Японы эдийн засгийн хамтын ажиллагааны өнөөгийн дүр төрхийг цөөн үзүүлэлтээр тоймлон авч үзэхэд ийм байна.

Хятадын газар нутаг, ажиллах хүчний арвин их нөөц, японы шинжлэх ухаан техникийн дэвшил, хөрөнгө хүчний асар их давуу талыг нэгтгэж, энэ чиглэлд гарч буй зарим зөрчлийг хамтын хүчин чармайлтаар зохицуулж харилцан ашигтай, үр өгөөжтэй хэлбэрийг сонгон олж, хоёр орны хооронд тогтсон худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагаа жил ирэх бүр улам өргөжин гүнзгийрэх шинж төлөвт нэгэнт оржээ гэж үзэж болохоор байна.